



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 02 сарын 10-ны
өдрийн 572 дугаарт бүртгэв.

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 14


Мандалговь

Малын тоо толгойн албан татвар
тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2-ын "д", Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь :

1. Сумын малын тоо толгойн албан татварыг Хонь 400 төгрөг, Ямаа 500 төгрөг, Тэмээ 0 төгрөг, Үхэр 0 төгрөг, Адуу 1500 төгрөг байхаар тогтоож баталсугай.
2. Малчны амьжиргааг дэмжих зорилгоор "малчин" өрхийн гишүүн тутамд 25 хонин толгойг чөлөөлж татварыг тооцсугай.
3. Жилийн эцсийн мал тооллогоор зөвхөн адуу тоолуулсан малчин өрхөд хөнгөлөлт үзүүлэх тохиолдолд Үндэсний статистикийн хорооны бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициентийг мөрдөж ашигласугай.
4. Малын тоо толгойн албан татварыг хоёр хуваан сумын төсөвт 7 сарын 15, 12 сарын 15-ны дотор төвлөрүүлэн хэрэгжилтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг сумын Засаг дарга (С Бат-Оргил), татварын улсын байцаагч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
5. Малын тоо толгойн татварыг батлагдсан төлбөрийн дагуу аж ахуйн нэгж, албан байгууллага, малчин айл өрхүүд, мал бүхий иргэдэд мөрдүүлж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (С.Бат-Оргил), ХАА-н тасгийн дарга (Ш.Бямба) нарт даалгасугай.
6. Энэхүү тогтоолыг Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлснээр дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ

Бүртгэлийн дугаар 07

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2021 оны 02 сарын 04 ний өдөр